



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 822

Улаанбаатар хот

Үл хөдлөх эд хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 152 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай, улсын бүртгэлийн Э-2204900133 дугаартай 8190.0 м² газар эзэмших эрх бүхий агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийг дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. “Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн дуудлагын худалдааны доод үнийг 1,717,528,000.0 (нэг тэрбум, долоон зуун арван долоон сая, таван зуун хорин найман мянган) төгрөгөөр тогтоосугай.

3. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн дуудлагын худалдааны дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар, үнэ хаялцах доод хязгаарыг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр, дээд хязгаарыг дэнчингийн хэмжээгээр тус тус тогтоосугай.

4. Дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

5. Дуудлагын худалдааны ялагчтай байгуулах Худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

6. Дуудлагын худалдааны орлогыг Засгийн газрын 2024 оны 152 дугаар тогтоолын 2-т заасны дагуу Дархан-Уул аймагт шилжин байрлах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа Засгийн газрын агентлаг, улсын төсвийн байгууллага, төрийн өмчит компанийн албан хаагчдад зориулсан албан хэрэгцээний орон сууц худалдан авахад зарцуулсугай.

7. Шинэ өмчлөгчид шилжих хүртэл хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын

газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг (В.Дарханбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

8.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
822 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ

(Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай, агуулах, аж ахуйн барилга, байгууламж,
газар эзэмших эрх)

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Хэмжээ	Балансын үнэ (төгрөгөөр)	Дуудлага худалдааны доод үнэ (төгрөгөөр)
1	Оффисын барилга	2014	м.кв	200.0	111,179,390.00	216,266,000.00
2	Агуулах № 1	2019	м.кв	1296.0	287,077,517.00	287,078,000.00
3	Агуулах № 2	2019	м.кв	1296.0	285,620,271.00	285,620,000.00
4	Граж /4 машины/	2019	м.кв	136.0	59,371,544.00	89,611,000.00
5	Бетон хашаа	2019	м.кв	120.0	2,646,483.84	6,257,000.00
6	Блокон хашаа	2019	м.кв	36.26	2,078,778.24	3,025,000.00
7	Модон хашаа	2014	м.кв	304.98	4,138,454.00	5,807,000.00
8	Бетон талбай	2019	м.кв	97.0	880,595.00	3,847,000.00
9	Төмөр хаалга /2 ширхэг/ Барилга, байгууламжийн дүн	2014	м.кв	2	1,344,606.00 754,337,639.08	1,345,000.00 898,856,000.00
10	8190.0 м.кв эзэмшил газрын эрх /Э-2204900133/	2015	м.кв	8190	84,357,000.00	818,672,000.00
	Нийт дүн				838,694,639.08 (найман зуун гучин найман сая зургаан зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун гучин есөн төгрөг найман мөнгө)	1,717,528,000.00 (нэг тэрбум долоон зуун арван долоон сая таван зуун хорин найман мянга)